Тус байгууллага нь аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтсээс 2021 онд боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 130.437.2 мянган төгрөг буюу 10.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	174,822.1	87,031.0	(87,791.0)
Мөнгөн хөрөнгө	103,240.4	19,885.1	(83,355.3)
Авлага	1,679.9	19,094.9	17,415.0
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	69,901.8	48,051.0	(21,850.7)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,100,671.7	1,058,025.5	(42,646.2)
Үндсэн хөрөнгө	1,403,968.6	1,452,830.6	48,862.0
Хуримтлагдсан элэгдэл	(303,297.0)	(394,805.1)	(91,508.2)
Нийт хөрөнгө	1,275,493.8	1,145,056.5	(130,437.2)
Өр төлбөр	2,930.0	682.4	(2,247.6)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,272,563.7	1,144,374.2	(128,189.6)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,275,493.8	1,145,056.5	(130,437.2)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 19.885.1 мянган төгрөг байгаа нь ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газрын санхүү, даатгалын хэлтсээс өгсөн чиглэлийн дагуу тайлант хугацааны төсвийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлээгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл өмнөх оноос 17.415.0 мянган төгрөгөөр өссөн бөгөөд энэ нь эрүүл мэндийн даатгалаас авах авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж, тусгасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 48.051.0 мянган төгрөг болж 21.850.7 мянган төгрөгөөр буурч байна.

Төсвийн худалдан авалтаар 245.421.2 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч, хандиваар 2.955.0 мянган төгрөгийн, аймгийн Эрүүл мэндийн газраас 17.066.7 мянган төгрөгийн аж ахуйн материал үнэ төлбөргүйгээр хүлээн авсан бөгөөд 269.567.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1.452.830.6 мянган төгрөг болж 48.862.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн худалдан авалтаар 17.075.1 мянган төгрөгийн, хандиваар 17.300.0 төгрөгийн, Аймгийн Эрүүл мэндийн газраас үнэ төлбөргүй хүлээн авсан 14.486.9 мянган төгрөгийн машин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 682.4 мянган төгрөг байгаа нь тайлант оны ХХОАТ-ын өглөг 354.0 мянган төгрөг, 2019 оны эмийн тооцооны барагдуулаагүй өглөг 328.4 мянган төгрөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1.144.374.2 мянган төгрөг болж 128.189.6 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 128.189.6 мянган төгрөгөөр буурсантай холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд эрүүл даатгалын сангаас санхүүжих эх үүсвэрийг 579.640.0 мянган төгрөгөөр төсөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант хугацаанд нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг хүн амд үзүүлэх тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотой анх батлагдсан төсөвт 4 удаа төсөвт өөрчлөлт оруулжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээр 771.210.2 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 44.003.8 мянган төгрөгийн, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 70.0 мянган төгрөгийн, нийт 815.284.0 мянган төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 895.951.6 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд өмнөх оны үлдэгдлээс 80.355.3 сая төгрөгийг тайлант оны урсгал үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Дд	Хөтөлбөр, арга хэмжээ	Зарцуулах эрх	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602 Эмнэлгийн тусламж үйлчилгээ	988,283,400.00	895,881,643.80	92,401,756.20	92,401,756.20
2	80112 Нийтлэг үйлчилгээ	44,003,800.00	41,316,122.64	2,687,677.36	2,687,677.36
3	80302 Нэг иргэнд ногдох нормативаар	604,899,500.00	536,657,287.04	68,242,212.96	68,242,212.96
4	81603 Үндсэн мэргэжлийн тусламж үйлч	236,139,700.00	230,302,828.12	5,836,871.88	5,836,871.88
5	83603 Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	103,240,400.00	87,605,406.00	15,634,994.00	15,634,994.00

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилтийн данс байхгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд шатахууны зардалд 30.844.0 мянган төгрөг, хоолны зардалд 20.234.0 мянган төгрөгийн төсөв батлагдаж, нээлттэй тендер шалгаруулалтаар “НИК” ХХК-тай шатахуун нийлүүлэх гэрээ, “ОСЕГ” ХХК-тай хоол, хүнс нийлүүлэх гэрээ байгуулан ажиллажээ.

Тус байгууллага нь түлш халаалтын зардалд нийт 36.115.5 мянга, гэрэл цахилгааны зардалд 5.188.3 мянга, цэвэр бохир усны зардалд 1.200.0 мянган төгрөг батлагдсанаас “Баянхонгор эко дулаан” ХХК-тай дулаанаар хангах гэрээ, “Баянхонгор-Эрчим хүч” ЦТХХК-тай цахилгаанаар хангах гэрээг тус тус байгуулж ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Цэвээнсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны жилийн

эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 3 дугаар улирлын үйл ажиллагааны зардлын дүн 596.968.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 5.969.7 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 4.477.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь аймгийн Эрүүл мэндийн газраас ирүүлсэн чиглэлийг мөрдөж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил илрээгүй.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар зөрчил илрээгүй.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь “Глобал капитал аудит” ХХК-ийн аудитор Д.Цэцэгмаа гүйцэтгэж, аудитаар 10.000.0 мянган төгрөгийн 3 зөвлөмж, 11.931.7 мянган төгрөгийн 3 төлбөрийн акт тогтоосноос 10.000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг хуулийн байгууллагад шилжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	3	11.931.7	2	1.319.9	66.67%
Албан шаардлага	-	-	-	-	-

Зөвлөмж	3	10.000.0	3	10.000.0	100.00%
Нийт дүн	6	11.931.7	7	10.319.5	83.33%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал:

Өмнөх оны Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 2023 оны 02 сарын 17-ны өдрийн 19/14425182 тоот төлбөрийн актаар тухайн үеийн Эрүүл мэндийн төвийн дарга Б.Гантулга, нягтлан бодогч М.Отгондалай нараар 10.000.0 мянган төгрөгийг төлүүлэхээр тогтоосон нь шүүхэд шилжсэн бөгөөд актын төлбөр төлөгдөөгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 26.266.7 мянган төгрөгийн 3 зөрчил¹ илэрснээс 1.500.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 24.726.7 мянган төгрөгийн 2 албан шаардлага өгсөн.

Дээрх зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

5.1 Төлбөрийн акт

5.1.1 Байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Б/30 тоот тушаалаар "Төрийн дээд одон медаль хүртсэн эмч, мэргэжилтэн, ажилчдад урамшуулал олгох" жагсаалтын дагуу 8 албан хаагчид нийт 1.500.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон. Тус тэтгэмжийг хамтын гэрээнд заасны дагуу олгосон бөгөөд тус байгууллагын хамтын гэрээ нь 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан байна. Хамтын гэрээ батлагдсанаас хойш 1 албан хаагч "Алтан гадас" одонгоор шагнагдсан бөгөөд бусад нь 2019 оноос шагнагдсан хүмүүс байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл, 15.1.3 хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагч Б.Ундармаагаар 1.500.0 мянган төгрөгийг буцаан төлүүлэхээр төлбөрийн актыг тогтоов.

5.2 Албан шаардлага

5.2.1 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/28 тоот Мөнгөн урамшуулал олгох тухай байгууллагын даргын тушаалаар 21.979.0 төгрөгийн урамшууллыг өмнөх оны төсвийн хэмнэлтээс нийт албан хаагчдад олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.6 "Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагад энэ хуулийн 44.5.1, 46.3 хамаарахгүй", 46.3 "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэлд үндэслэн дараах арга хэмжээнд зарцуулж болно" заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5.2.2 Тайлант онд Аймгийн Эрүүл мэндийн газрын 100030020401 тоот данс руу эмийн өглөг 2.700.0 мянган төгрөгийг цалингийн зардлаас төлсөн байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл 22.1 Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн тайлагнана, 22.2 Төсвийг дор дурдсаны дагуу ангилна, 22.2.3 эдийн засгийн ангиллаар заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Төлбөрийн акт		Үүнээс Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Б/30 тоот байгууллагын даргын тушаалаар "Төрийн дээд одон медаль хүртсэн эмч, мэргэжилтэн, ажилчдад урамшуулал олгох" жагсаалтын дагуу 2019 оноос хойш шагнагдсан 8 албан хаагчид нийт 1.500.0 мянган төгрөгийн нэг удаагийн тэтгэмж олгосон.	1	1.500.0	1	1.500.0				
2023 оны 12 сарын 25-ны өдөр Аймгийн ЭМГ-ын 100030020401 тоот дансруу эмийн өглөг 2.747.7 мянган төгрөгийг цалингийн зардлаас шилжүүлсэн нь Сангийн сайдын 2021 оны 10 сарын 29-ний өдрийн 190 тоот тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг зөрчсөн байна.	1	2.747.7			1	2.747.7		
2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/28 тоот Мөнгөн урамшуулал олгох тухай байгууллагын даргын тушаалаар 21.979.0 мянган төгрөгийн урамшууллыг өмнөх оны төсвийн хэмнэлтээс нийт албан хаагчдад олгосон байна. Урамшууллыг "Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллыг дэмжих" сарын хүрээнд олгосон.	1	21.979.0			1	21.979.0		
Нийт дүн	3	26.226.7	1	1.500.0	2	24.726.7		

-----oO-----



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 50/А0591212/БНА-2024/145/НА-СТА-ТШЗ Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан хамтын гэрээг үндэслэн байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Б/30 тоот “Төрийн дээд одон медаль хүртсэн эмч, мэргэжилтэн, ажилчдад урамшуулал олгох” тушаалаар 1,500,000 (Нэг сая таван зуун мянган төгрөг)-ийн нэг удаагийн тэтгэмжийг 2019-2022 онуудад төрийн дээд одон медалиар шагнагдсан 8 албан хаагчид нөхөж олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрхзүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.3 дахь “Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон”, 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Дээрх 1,500,000 (Нэг сая таван зуун мянган төгрөг)-ийг төсөв захирагчаар төлүүлж Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.

5050206

2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 04 дүгээр сарын 25-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг Галуут сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Ундармаа, нягтлан бодогч Б.Цэндсүрэн нарт даалгав^{2,3}.

ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН⁴:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ
АУДИТОР С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

² Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана"

³ Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

⁴ Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 23 өдөр

Дугаар 89/АД592.12/БНА-2024/145/
НА-СТА-ТЦЗ

Номгон

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын даргын 2023 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн А/28 тоот “Мөнгөн урамшуулал олгох тухай” тушаалаар 21,979,000 (Хорин нэгэн сая есөн зуун далан есөн мянган төгрөг)-ийн урамшууллыг өмнөх оны төсвийн хэмнэлтээс нийт албан хаагчдад олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 46 дугаар дугаар зүйлийн 46.6 “Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг төрийн үйлчилгээний байгууллагад энэ хуулийн 46.3 хамаарахгүй” заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.


5040316

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галуут сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Ундармаа, нягтлан бодогч Б.Цэндсүрэн нарт даалгав^{1, 2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Б.МӨНХБАТ

АУДИТОР:  С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

᠒᠐᠒4 оны ᠐᠘ сарын ᠒3 өдөр

Дугаар 90/᠕᠐571212/БНА - 2024/1᠑5/ Номгон
НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Галуут сумын Эрүүл мэндийн төвийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд Аймгийн Эрүүл мэндийн газрын 100030020401 тоот данс руу эмийн өглөг 2,747,718 (Хоёр сая долоон зуун дөчин долоон мянга долоон зуун арван найман төгрөг)-ийг төлөхдөө цалингийн зардлаас шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн тайлагнана” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, зөрчлийг арилгаж, нотлох баримтыг FAS системд оруулж, биелэлтийг 2024 оны 06 дүгээр сарын 30-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

5040320


2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Галуут сумын Эрүүл мэндийн төвийн дарга Б.Ундармаа, нягтлан бодогч Б.Цэндсүрэн нарт даалгав^{1,2}.

АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН³:

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР: Б.МӨНХБАТ

АУДИТОР:

С.ЦЭВЭЭНСҮРЭН



¹ Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

² Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

³ Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно